

## **БҮХ ХЯТАДЫН АРДЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ИХ ХУРЛЫН АРАВ ДАХЬ УДААГИЙН СОНГУУЛИЙН АНХДУГААР ЧУУЛГАНЫ ТУХАЙ**

Н.Төмөр\*

Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал /БХАТИХ/-ын арав дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган 2003 оны 3-р сарын 5-18-нд Бээжинд болов. БНХАУ-ын муж, өөртөө засах орон, хот болон Ардын чөлөөлөх армиас сонгогдсон 2983 төлөөлөгчид их хуралд оролцсоноос 70 хувь нь шинээр сонгогдожээ.

Уг чуулганд Засгийн газрын ажлын тухай тайлан илтгэлийг БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Жу Рунжи, Улс ардын аж ахуй, нийгмийг хөгжүүлэх 2002 оны төлөвлөгөөний биелэлт, 2003 оны төлөвлөгөөний төслийн тухай илтгэлийг Улсын хөгжил, төлөвлөгөөний комиссын дарга Зэн Пэйян, 2002 оны улсын төсвийн гүйцэтгэл, 2003 оны төсвийн төслийн тухай илтгэлийг Сангийн Яамны сайд Сян Хуэйчэн, БХАТИХ-ын Байнгын Хорооны ажлын тухай тайлан илтгэлийг БХАТИХ-ын Байнгын Хорооны дарга Ли Пэн, Ардын дээд шүүхийн ажлын тухай тайлан илтгэлийг Ардын дээд шүүхийн дарга Сяо Ян, Ардын дээд прокурорын газрын ажлын тухай тайлан илтгэлийг Ардын дээд прокурорын газрын ерөнхий прокурор Хань Жубин нар тус тус тавив.

БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Жу Рунжи, Засгийн газрын ажлын тухай тайлан илтгэлдээ, БНХАУ-ын эдийн засгийн хөгжлийн асуудал, гадаад бодлогын үндсэн чиглэлийн талаар тодорхой ярих. Тэрээр эдийн засагт олсон амжилтын талаар хэлэхдээ, 2002 оны байдлаар, БНХАУ-ын дотоодын нийт бүтээгдэхүүний нийт хэмжээ 10200 тэрбум юаньд хүрсэн бөгөөд ДНБ-ний нийт хэмжээ нь өнгөрсөн таван жилд дунджаар 7,7%-иар өсөн нэмэгдэж, IX таван жилийн төлөвлөгөөг амжилттай биелүүлэв гэж тэмдэглээд, ард түмний амьдралын түвшин дээшилж, 2002 онд хотын хүн амын дундаж орлого 7703 юаньд хүрч, жилд дунджаар 8,6%, хөдөө тосгоны хүн амын дундаж орлого 2476 юаньд хүрч, жилд дунджаар 3,8% нэмэгдэв гэжээ. Жу Рунжи илтгэлдээ, өнгөрсөн таван жилд тус улсын санхүү эдийн засгийн байдал сайн байгааг тэмдэглээд, 2002 оны байдлаар экспорт, импортын нийт хэмжээ 620,8 тэрбум ам.долларт хүрсэнээс экспортын

---

Н.Төмөр - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

хэмжээ 325,6 тэрбум ам.доллар, гадаад валютын нөөц 286,4 тэрбум ам.доллар болсон байна гэж тэмдэглэжээ.

БНХАУ-д 2002 оны байдлаар, 457,11 сая тн үр тариа, 101,51 сая тн чихрийн ургамал, 29 сая тн тосны ургамал, 4,9 сая тн хөвөн, 13,8 дүнчүүр тн нүүрс, 1,67 дүнчүүр тн газрын тос, 1654 тэрбум киловат/цаг эрчим хүч, 181,55 сая тн болд, 10,12 сая тн өнгөт металл, 7,25 дүнчүүр тн цемент, 37,91 сая тн химийн бордоо, 3,251 сая ачааны машин, 1,092 сая суудлын машин тус тус үйлдвэрлэв гэж “БНХАУ-ын Улс ардын аж ахуй, нийгмийн хөгжлийн 2002 оны статистикийн мэдээ”-нд дурджээ.

Жу Рунжи тус орны эдийн засаг түргэн хурдацтай хөгжиж буйг тэмдэглээд улс орныхоо эдийн засгийг цаашид улам эрчимтэй хөгжүүлэхийн тулд дор дурдсан саналууд дэвшүүлжээ. Үүнд:

1. Хөдөө аж ахуй, хөдөө тосгоны эдийн засгийг бүх талаар хөгжүүлэн, хөдөө аж ахуйн эдийн засагт бүтцийн өөрчлөлт, зохицуулалт хийж мал аж ахуй, далайн ургамал, амьтныг үржүүлэх аж ахуй, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрийг ихээхэн хөгжүүлэх.,

2. Баруун бүс нутгийг хөгжүүлэх бодлогыг цаашид хэрэгжүүлэн, тус бүс нутгийн дэд бүтэц, экологийн бүтээн байгуулалтыг эрчимтэй явуулан, аж үйлдвэрийн хоцрогдсон тоног төхөөрөмж, байгаль орчныг бохирдуулдаг үйлдвэр аж ахуйн газруудыг Баруун бүс нутагт оруулахгүй байх., Зүүн хойд хятад болон аж үйлдвэр дээр үеэс хөгжсөн газар нутагт хийх зохицуулалт, өөрчлөлт шинэчлэлд дэмжлэг үзүүлэн үр дүнтэй арга хэмжээ авах.,

3. Эдийн засгийн тогтолцоонд хийх өөрчлөлт шинэчлэлийг цаашид гүнзгийрүүлэн, гадаад орнуудад нээлттэй байх явдлыг өргөтгөн, гадаадын хөрөнгө оруулалтыг үр ашигтай зарцуулан, гадаадын тэргүүний техник технологи, орчин үеийн удирдан зохион байгуулах туршлагыг нэвтрүүлэх., олон тал, хоёр тал болон бүс нутгийн хамтын ажиллагааг идэвхтэй урагшуулах шаардлагатай гэжээ.

Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Жу Рунжи илтгэлийнхээ гадаад бодлогын хэсэгт, “Бид биеэ даасан энх тайванч гадаад бодлогыг тууштай баримтлана. Хөгжиж буй орнуудтай эв санааны нэгдэл, хамтын ажиллагаагаа цаашид бэхжүүлэн хөгжүүлж, бүс нутгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэн, хөрш орнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа шинэ түвшинд хүргэнэ. Хөгжингүй орнуудтай харилцаагаа цаашид сайжруулан хөгжүүлж, энх тайвнаар зэрэгцэн

орших таван зарчмын үндсэн дээр нийтлэг эрх ашгийг өргөтгөн, зөрчлийг зохистой шийдвэрлэнэ” гэж дурджээ.

БХАТИХ-ын арав дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулганаар БНХАУ-ын даргаар Ху Зиньтао, орлогч даргаар Зэн Чинхун нарыг, БНХАУ-ын Цэргийн Төв Зөвлөлийн даргаар Зян Зэменийг, БХАТИХ-ын Байнгын Хорооны даргаар У Банго, дэд даргаар Ван Жаого, Ли Теин, Исмайил Аймаг /уйгур үндэстэн/, Хэ Лули, Дин Шисунь, Чэн Сывэй, Сюй Жалу, Жян Жэнхуа, Гу Сюйлянь, Реди /төвд үндэстэн/, Шэн Хуашэнь, Лу Юнсянь, Оюунчимэг /монгол үндэстэн/, Хань Чидэ, Фу Тешэнь нарыг, нарийн бичгийн даргаар Шэн Хуаренийг, гишүүнээр 159 хүнийг, Ардын дээд шүүхийн даргаар Сяо Яныг, Ардын дээд прокурорын газрын ерөнхий прокуророор Жа Чуньванийг тус тус сонгожээ.

БХАТИХ-ын арав дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулганы шийдвэрийг үндэслэн БНХАУ-ын даргын зарлигаар Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдаар Вэнь Жябао-г, Ерөнхий сайдын орлогчоор Хуан Зюй, У И, Зэн Пейян, Хуэй Ляньюй нарыг, гишүүнээр Жоу Юнкан, Цао Ганьчуань, Тан Жасюань, Хуа Зяньминь, Чэнь Жили нарыг, нарийн бичгийн даргаар Хуа Зяньминийг, Гадаад явдлын Яамны сайдаар Ли Жаосинийг, Батлан хамгаалах яамны сайдаар Цао Ганьчуанийг, Улсын хөгжил ба өөрчлөлт шинэчлэлийн хорооны даргаар Ма Кай зэрэг 28 яамны сайд, хорооны дарга нарыг томилов.

Шинээр сонгогдсон БНХАУ-ын дарга Ху Зиньтао 1942 онд Аньхой мужид төрж, 1964 онд ХКН-д элсэн, 1965 онд Бээжингийн Чинхуа их сургуулийн Усны аж ахуйн барилга байгууламжийн факультетийг төгсчээ. Тэрээр БНХАУ-ын даргаар сонгогдохоос өмнө 1999-2002 онд ХКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны Байнгын Хорооны гишүүн, ХКН-ын Төв Хорооны Нарийн бичгийн дарга нарын Газрын нарийн бичгийн дарга, ХКН-ын Цэргийн Төв Зөвлөлийн дэд дарга, БНХАУ-ын дэд дарга, БНХАУ-ын Цэргийн Төв Зөвлөлийн дэд дарга, ХКН-ын Төв Хорооны дэргэдэх Намын сургуулийн захиралаар ажиллаж байгаад 2002 оны арваннэгдүгээр сард ХКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, ХКН-ын Цэргийн Төв Зөвлөлийн дэд дарга, БНХАУ-ын дэд дарга, БНХАУ-ын Цэргийн Төв Зөвлөлийн дэд дарга болов.

Мөн шинээр сонгогдсон БХАТИХ-ын Байнгын Хорооны дарга У Банго 1941 онд Аньхой мужид төрж, 1964 онд ХКН-д элсэн, 1967 онд Бээжингийн Чинхуа их сургуулийг Электрон вакуумын тоног төхөөрөмжийн мэргэжлээр төгсчээ. Тэрээр БХАТИХ-ын Байнгын

Хорооны даргаар сонгогдохоос өмнө 1999-2002 онд ХКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны гишүүн, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдын орлогчоор ажиллаж байгаад 2002 оны арваннэгдүгээр сард ХКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны Байнгын Хорооны гишүүн, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдын орлогч болов.

БХАТИХ-ын арав дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулганы шийдвэрийг үндэслэн, БНХАУ-ын даргын зарлигаар томилогдсон БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Жябао 1942 онд Тяньжинь хотод төрж, 1965 онд ХКН-д элсэн, 1968 онд Бээжингийн Геологийн дээд сургуулийн аспирантурыг Геологийн бүтцийн мэргэжлээр төгссөн. Тэрээр БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдаар томилогдохоос өмнө 1998-2002 онд ХКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны гишүүн, ХКН-ын Төв Хорооны Нарийн бичгийн дарга нарын Газрын нарийн бичгийн дарга, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдын орлогчоор ажиллаж байгаад 2002 оны арваннэгдүгээр сард ХКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны Байнгын Хорооны гишүүн, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдын орлогч болов.